



## НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/198

Улаанбаатар хот

### Ор хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/266 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Персон ХХК-ний “Персон” эмнэлэгт өвчний удаан явц архаг үеийн эмчилгээний 5 ор нэмэлтээр, Наркологийн эмнэлэгт өдрийн эмчилгээний 10 ор нэмэлтээр, Сод-Эра ХХК-ний “Улаанбаатар хоспис” эмнэлэгт хөнгөвчлөх эмчилгээний - 15 ор, Энх-Амаржин ХХК-ний “Сувилахуйн төв”-д сувилахуйн тусламж, үйлчилгээний-20 ор, Улзын ундарга ХХК-ний “Сувилахуйн төв”-д сувилахуйн тусламж, үйлчилгээний-40 ор тус тус хуваарилсугай.

2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/100 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын 5-д заагдсан Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн “Эрхэс” нэгдсэн эмнэлгийн нэрийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 93 тоот албан хүсэлтийг үндэслэн “Их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэг” болгон өөрчилсүгэй.

Эрүүл мэндийн байгууллагын батлагдсан орны хязгаарт багтаан үзүүлж буй тусламж, үйлчилгээнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /М.Мөнхдэлгэр/-т даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс /Г.Баянжаргал/- т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500404